

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТЭД 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР  
ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО:**

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Барилга, хот байгуулалтын яамны хийж гүйцэтгэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулан яам, холбогдох дээд байгууллагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангахад хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

**ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТҮВШИН ҮНЭЛСЭН БАЙДАЛ:**

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дугаар тогтоолоор тус, тус батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

**ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дүгээр тогтоолоор баталсан 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2023 оны байдлаар 32 зорилт, 79 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилтийн түвшин 2023 оны жилийн байдлаар **84.68** хувьтай, “Үр дүнд хүрсэн” гэж үнэлэв. Үүнд: 100 хувьтай хэрэгжсэн 50, 90 хувьтай хэрэгжсэн 2, 70 хувьтай хэрэгжсэн 14, 50 хувьтай хэрэгжсэн 7, 30 хувьтай хэрэгжсэн 6, 0 хувьтай хэрэгжсэн 0 заалт бүхий ажлууд байна.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг харуулбал:

| № | Үзүүлэлт                   | Зорилт | Нийт арга хэмжээний тоо | Үүнээс |     |     |     |     |    | Хүснэгт 1<br>дундаж үнэлгээ /%/ |
|---|----------------------------|--------|-------------------------|--------|-----|-----|-----|-----|----|---------------------------------|
|   |                            |        |                         | 100%   | 90% | 70% | 50% | 30% | 0% |                                 |
| 1 | ЗГҮАХХАХ Т-ийн арга хэмжээ | 32     | 79                      | 50     | 2   | 14  | 7   | 6   | 0  | <b>84,68</b>                    |

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:

| №1 | Бодлого                |                |                       |                |                       |                |                    |                |                         |                |   |                |
|----|------------------------|----------------|-----------------------|----------------|-----------------------|----------------|--------------------|----------------|-------------------------|----------------|---|----------------|
|    | 2                      |                | 3                     |                | 3                     |                | 4                  |                | 5                       |                | 6   |                |
|    | Хүний хөгжлийн бодлого | Гүйцэтгэл хувь | Эдийн засгийн бодлого | Гүйцэтгэл хувь | Эдийн засгийн бодлого | Гүйцэтгэл хувь | Засаглалын бодлого | Гүйцэтгэл хувь | ногоон хөгжлийн бодлого | Гүйцэтгэл хувь | нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого | Гүйцэтгэл хувь |
| 1  | 2.1.3.11               | 100            | 3.5.7.1               | 100            | 3.7.5.1               | 100            | 4.2.5.6            | 100            | 5.1.1.4                 | 100            | 6.1.9.2                                       | 100            |
| 2  | 2.1.12.6               | 100            | 3.5.7.2               | 100            | 3.7.6.2               | 100            | 4.2.7.6            | 100            | 5.1.4.1                 | 100            | 6.1.10.1                                      | 100            |
| 3  | 2.1.14.2               | 100            | 3.7.1.1               | 100            | 3.7.7.1               | 100            | 4.2.10.2           | 100            | 5.1.4.2                 | 100            | 6.1.10.2                                      | 90             |



|    |          |     |         |     |          |     |  |  |          |     |          |     |
|----|----------|-----|---------|-----|----------|-----|--|--|----------|-----|----------|-----|
| 4  | 2.2.3.8  | 100 | 3.7.1.2 | 100 | 3.7.7.2  | 100 |  |  | 5.1.9.1  | 100 | 6.1.10.3 | 70  |
| 5  | 2.3.9.7  | 100 | 3.7.1.3 | 70  | 3.7.7.3  | 100 |  |  | 5.1.12.2 | 70  | 6.2.2.2  | 50  |
| 6  | 2.6.1.7  | 50  | 3.7.1.4 | 100 | 3.7.8.1  | 50  |  |  | 5.1.12.6 | 100 | 6.2.2.3  | 30  |
| 7  | 2.6.1.11 | 100 | 3.7.1.5 | 70  | 3.7.9.1  | 70  |  |  | 5.1.12.7 | 100 | 6.2.7.1  | 100 |
| 8  | 2.6.3.2  | 70  | 3.7.1.6 | 100 | 3.7.9.2  | 30  |  |  |          |     | 6.2.7.2  | 50  |
| 9  |          |     | 3.7.2.1 | 50  | 3.7.9.3  | 30  |  |  |          |     | 6.2.9.11 | 100 |
| 10 |          |     | 3.7.2.2 | 30  | 3.7.9.4  | 70  |  |  |          |     | 6.2.11.1 | 70  |
| 11 |          |     | 3.7.2.3 | 50  | 3.7.9.5  | 30  |  |  |          |     |          |     |
| 12 |          |     | 3.7.2.4 | 50  | 3.7.9.6  | 100 |  |  |          |     |          |     |
| 13 |          |     | 3.7.2.5 | 100 | 3.7.9.7  | 100 |  |  |          |     |          |     |
| 14 |          |     | 3.7.2.6 | 100 | 3.7.9.9  | 100 |  |  |          |     |          |     |
| 15 |          |     | 3.7.3.1 | 100 | 3.7.10.1 | 100 |  |  |          |     |          |     |
| 16 |          |     | 3.7.3.2 | 100 | 3.7.11.3 | 100 |  |  |          |     |          |     |
| 17 |          |     | 3.7.3.3 | 70  | 3.7.11.4 | 100 |  |  |          |     |          |     |
| 18 |          |     | 3.7.3.4 | 100 | 3.7.11.5 | 100 |  |  |          |     |          |     |
| 19 |          |     | 3.7.3.5 | 90  | 3.7.11.6 | 70  |  |  |          |     |          |     |
| 20 |          |     | 3.7.3.6 | 100 | 3.7.12.3 | 100 |  |  |          |     |          |     |
| 21 |          |     | 3.7.3.7 | 30  | 3.7.12.4 | 100 |  |  |          |     |          |     |
| 22 |          |     | 3.7.3.8 | 70  | 3.7.13.1 | 70  |  |  |          |     |          |     |
| 23 |          |     | 3.7.4.1 | 100 | 3.7.13.2 | 70  |  |  |          |     |          |     |
| 24 |          |     | 3.7.4.2 | 100 | 3.7.13.3 | 100 |  |  |          |     |          |     |
| 25 |          |     | 3.7.4.3 | 100 |          |     |  |  |          |     |          |     |
| 26 |          |     | 3.7.4.6 | 70  |          |     |  |  |          |     |          |     |
| 27 |          |     | 3.7.4.7 | 100 |          |     |  |  |          |     |          |     |

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 2023 онд дараах арга хэмжээнүүд үр дүнтэй хэрэгжсэн байна:

3.5.7.1. Хөшигийн хөндийд баригдах бүтээн байгуулалттай холбоотой дулаан, цахилгааны эх үүсвэрүүдийг судалж, үе шаттай хэрэгжүүлнэ

3.7.4.7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээг эрэмбэлэн, зураг төслийг боловсруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

3.7.9.7. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд 30 000 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.7.10.1. Бага, дунд орлоготой иргэдийг жилийн 4-6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлд хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлж, зээл олгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулна.

3.7.11.5. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 11 аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. /58.5 сая ам.доллар/

3.7.13.3. Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.

4.2.7. 6. Барилга, хот байгуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

6.1.9. 2. Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвүүдийн хот хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.

2.1.3.11, 2.1.12.6, 2.1.14.2, 2.2.3.8. 2.3.9.7. Захиалгын дагуу Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, боловсролын байгууллагуудын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ариун цэврийн байгууламжийг сайжруулах, барилга

байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар “Эрчимжүүлэх шаардлагатай” 50%-ийн хэрэгжилттэй 7, “Үр дүнгүй” 30%-ийн хэрэгжилттэй 6, нийт 13 ажил байна.

Хэрэгжилт “Эрчимжүүлэх шаардлагатай” 50% биелэлттэй дараах 7 ажил байна. Үүнд:

2.6.1.11. Барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчинг шинэчлэн сайжруулж, улсын хэмжээнд байгаа түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг үе шаттайгаар бэхэлж, хүчитгэх ажлыг эхлүүлнэ.

3.7.2.1. Улсын хэмжээнд хот суурингийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.7.2.3. Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25 000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулна.

3.7.2.4. Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээг шинэчилж өндрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулна.

3.7.8.1. Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчин бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна.

6.2.2. 2. Аймгуудын барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг техник тоног төхөөрөмжөөр хангана.

6.2.7.2. Сумын хөгжил арга хэмжээг хэрэгжүүлж, инженерийн дэд бүтцийг барьж байгуулна.

Хэрэгжилт “Үр дүнгүй”, 30 хувьтай биелэлттэй дараах 6 ажил байна. Үүнд:

3.7.2.2. Навигацын хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станц /GNSS/-ыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил, зураглалын үйл ажиллагаанд ашиглана.

3.7.3.7. Улсын хэмжээнд ашиглагдаж буй барилга, байгууламжийн паспортжуулалт, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлж, цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулна.

3.7.9.2. "Солонго 1", "Солонго 2" төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.7.9.3. "Баянголын амны орон сууц" барих төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.7.9. 5. Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлнэ.

6.2.2.3. Барилгын материалын сорилт шинжилгээний төв лабораторийг өргөх машин механизм, цахилгаан утасны лаборатори, барилгын физикийн лабораторийн тоног төхөөрөмжөөр хангана.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ:**

1. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Барилга, хот байгуулалтын яамны хийж гүйцэтгэхээр тусгагдсан зорилт, арга

хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд үнэлгээ 84,68 хувьтай “Эрчимжүүлэх шаардлагатай” үнэлэгдэж байна.

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд жил бүр Улсын төсөвт 3.7.2.1, 3.7.2.2, 3.7.2.3, 3.7.2.4, 3.7.3.2, 3.7.3.3, 3.7.3.6, 3.7.3.7, 3.7.3.8, 3.7.4.6 зэрэг нийт 10 арга хэмжээнүүд нь жил бүрийн улсын төсөвт хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх санал хүргүүлсэн ч шийдвэрлэгддэггүй байна.

#### **ТАВ: САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

1. 3.7.2.1, 3.7.2.2, 3.7.2.3, 3.7.2.4, 3.7.3.2, 3.7.3.3, 3.7.3.6, 3.7.3.7, 3.7.3.8, 3.7.4.6 зэрэг нийт 10 арга хэмжээнүүд нь жил бүрийн улсын төсөвт хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх санал хүргүүлсэн ч шийдвэрлэгдэхгүй байгаад анхаарч ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ц.Ариунсанаа/, Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газар /Э.Батболд/ болон холбогдох газрын дарга нарт даалгах;

2. Үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7.9.2. "Солонго 1", "Солонго 2" төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна 1 арга хэмжээ болон 3.7.9.3. "Баянголын амны орон сууц" барих төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна, 3.7.9.4. Орлогод нийцсэн 10,000 орон сууцны эко хорооллын төслийг хэрэгжүүлэх, 3.7.9.5. Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлнэ зэрэг нийслэлийн ЗДТГ-аас хариуцан хэрэгжүүлж буй 3 арга хэмжээ, нийт 4 арга хэмжээг тал дээр онцгой анхаарч, хамтран ажиллахыг Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газар /Э.Батболд/, нийслэлийн Засаг дарга нарт чиглэл болгох;

3. Чиг үүргийн яамдтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт, хийгдэх ажил тодорхойгүй байгаа зэрэг асуудлуудыг цэгцэлж, нэг мөр болгох, төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтэд анхаарч ажиллахыг /Соёлын яам 2.6.1.7. Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театр, 2.6.3.2. Олон улсад өрсөлдөх чадвар бүхий соёл урлагийн чадварлаг хүний нөөцийг бэлтгэж, ажлын байраар хангах тогтолцоог сэргээнэ/ Барилга, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т даалгах;

4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан “Эрчимжүүлэх шаардлагатай” 50 хувьтай 7, “Үр дүнгүй” 30 хувьтай 6, нийт 13 арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, 2024 оны төлөвлөгөөнд тусган, төлөвлөгөө гарган ажиллахыг бүх газар, хэлтсүүдэд үүрэг болгох;

5. Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдан жил бүр Сангийн яам руу тухайн жилийн төсвийн төсөлд санал хүргүүлсэн боловч хөрөнгийн асуудал шийдэгдээгүй 3.7.2.1, 3.7.2.2, 3.7.2.3, 3.7.2.4, 3.7.3.2, 3.7.3.3, 3.7.3.6, 3.7.3.7, 3.7.3.8, 3.7.4.6, нийт 10 арга хэмжээг үнэлгээнээс хасах, нийслэлийн ЗДТГ-аас үндсэн хэрэгжүүлэгчээр хариуцан хэрэгжүүлж байгаа 3.7.9.3, 3.7.9.4, 3.7.9.5, нийт 3 арга хэмжээг хасаж хамтран хэрэгжүүлэгчээр оролцох бололцоог судлан шийдвэрлэж өгөхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт уламжлах.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ,  
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

